



ОРХОНТУУЛ СУМЫН
АРДЧИЛСАН НАМЫН ХОРООНД

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

213200 Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум
Цагаан Эрэг II баг
Утас: 7036-3040 Факс: (976)-7036-3040
E-mail: Selenge@audit.gov.mn

2020.07.30 № ОХА-2020/ОН-НА-28
танай _____-ны № _____-т

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн
дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Орхонтуул сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуульд оролцох Орхонтуул сумын Ардчилсан намын хорооны сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Орхонтуул сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуульд оролцох Орхонтуул сумын Ардчилсан намын хороо нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль болон “Алсын хараа-2050”-д нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцооны хамт ирүүлж, хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газар нь аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох нам, эвслийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817-1:2020 Тулгуур зарчим, Төрийн аудит MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, Төрийн аудит MNS 6817-8:2020 Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2020 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2020-2022 оны төсвийн төсөөллийн тухай хууль болон “Алсын хараа-2050”, холбогдох бусад байгууллагаас авсан мэдээллийг шалгуур болгосон.

018020603

Дүгнэлт

Орхонтуул сумын Ардчилсан намын хорооны Орхонтуул сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөр, түүнд орсон зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, "Алсын хараа-2050", Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Орхонтуул сумын Ардчилсан намын хорооны мөрийн хөтөлбөр
1...3... хуудас/-ийг хавсаргав.

Хувийг: Орхонтуул сумын Сонгуулийн хороонд

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН ОРХОНТУУЛ СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН 2020 ОНЫ
СОНГУУЛЬД ОРОЛЦОХ АРДЧИЛСАН НАМЫН МӨРИЙН ХӨТӨЛБӨР**

УРИА: ОРХОНТУУЛЧУУДЫН ХӨГЖЛИЙН ТӨЛӨӨ ХАМТДАА

Сэлэнгэ аймгийн Орхонтуул сумын Ардчилсан намын мөрийн хөтөлбөрийн зорилт нь эдийн засаг, нийгэм, засаглалын гурван тулгуурт бодлогыг хэрэгжүүлэн, төрөлжсөн эдийн засагтай, чанар, хүртээмжтэй нийгмийн суурь үйлчилгээг үзүүлсэн, шударга засаглал бүхий бүтээлч иргэдтэй жишиг сум болгоход оршино.

НЭГ.ЭДИЙН ЗАСАГ

1.1 Аж үйлдвэр

- 1.1.1 Сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэгч иргэдийн жижиг үйлдвэр, цех байгуулах санал санаачилгыг бодлогоор дэмжиж ажиллана.
- 1.1.2 Жинхэнэ жижиг дунд үйлдвэрлэгчдийг дэмжих сумын дэд хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ.


1.2 Хүнс хөдөө аж ахуй

- 1.2.1 Хадлан, дарш бэлтгэх, тэжээлийн үйлдвэрлэл эрхлэгчдийг бодлогоор дэмжинэ.
- 1.2.2 Малчдын хадлангийн техник хэрэгслийг шинэчлэх ажлыг холбогдох мэргэжлийн байгууллагуудтай хамтран зохион байгуулна.
- 1.2.3 Малчдыг сүүний чиглэлийн үхэр өсгүүлж, үржүүлэхэд бодлогоор дэмжин, хамтран ажиллана.
- 1.2.4 Малчдын бэлчээрт ойрхон тариалангийн талбайг тусгаарлах зорилго бүхий малчид тариаланчдын хамтарсан хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлнэ.
- 1.2.5 Төмс хүнсний ногоо тариалагчдыг дэмжих хөтөлбөрийг хэрэгжүүлж, борлуулалтыг нэмэгдүүлэх ажлыг бодлого, зохион байгуулалтаар хангаж ажиллана.
- 1.2.6 Гахай, шувуу, зөгий, загас болон бусад туслах аж ахуйг өрх, фермерийн аж ахуйн түвшинд хүргэх бодлого баримтлан ажиллана.
- 1.2.7 Малын үүлдэр угсааг сайжруулж, нийт малд өндөр ашиг шимт болон нутгийн шилмэл үүлдрийн малын эзлэх хувийг нэмэгдүүлэх ажлыг мэргэжлийн байгууллагатай хамтран зохион байгуулна.
- 1.2.8 Тариалангийн газар эзэмших, ашиглах эрхийн хяналтыг сайжруулж, хөрсний үржил шим бууруулсан нөхцөлд эзэмших, ашиглах эрхийг цуцлах эрх зүйн зохицуулалтыг мөрдүүлэн, хяналт тавьж ажиллана.

1.3 Дэд бүтэц

- 1.3.1 Сумандаа чанар стандартад нийцсэн спорт заал барьж байгуулах ажлыг санаачлан холбогдох дээд шатны байгууллага, албан тушаалтанд уламжлан, зардлыг улсын болон орон нутгийн төсөвт тусгуулна.
- 1.3.2 Сумын баяр наадмын талбайг шинэчлэн байгуулахаар холбогдох байгууллагад уламжилна.

- 1.3.3 Рашаант тосгонд залуучуудын чөлөөт цагийг өнгөрөөх шинэ “Спорт заал” барьж ашиглалтад оруулах ажлыг санаачлан холбогдох байгууллагад уламжлан шийдвэрлүүлнэ.
- 1.3.4 “Эко жорлон” хөтөлбөрийг Рашаант суманд хэрэгжүүлнэ.
- 1.3.5 Худалдаа, үйлчилгээ, бизнес эрхлэгчдийн ажиллах таатай орчин бүрдүүлж шинээр Худалдааны төв байгуулах ажлыг санаачлан дээд шатны байгууллага, албан тушаалтанд уламжлан шийдвэрлүүлнэ.
- 1.3.6 Сумын хогийн цэгийг хашаажуулна.



ХОЁР. НИЙГЭМ

2.1 Эрүүл мэнд

- 2.1.1. Эрүүл мэндийн даатгалаас олгогддог эмийн хөнгөлөлтийг тэгш, хүртээмжтэй олгох асуудалд мэргэжлийн байгууллага, мэргэжилтэнтэй хамтран хяналт тавьж ажиллана.
- 2.1.2. “Явуулын эмнэлэг”- ийн үйлчилгээг нэвтрүүлж, иргэдийг 2 жил тутамд эрүүл мэндийн үзлэгт хамруулах ажлыг санаачлан, холбогдох мэргэжлийн байгууллагатай хамтран зохион байгуулна.
- 2.1.3. Сумын эрүүл мэндийн төвийн барилга, байгууламж, тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг орчин үеийн стандарт шаардлагад нийцүүлэн үе шаттайгаар шинэчлэх хөрөнгө оруулалтыг холбогдох байгууллагад уламжлан шийдвэрлүүлнэ.
- 2.1.4. Олон нийтийн оролцоонд тулгуурлан “Архидалттай тэмцэх” сумын дэд хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ.

2.2. Боловсрол


- 2.2.1. СӨБ-ын байгууллагын анги танхимын хүрэлцээ муу байгаа тул хүүхэд харах үйлчилгээг дэмжих бодлого баримтлан ажиллана.
- 2.2.2. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, иргэний нийгмийн амьдралд тэгш оролцох боломжийг нэмэгдүүлсэн үйлчилгээг бодлогоор дэмжиж ажиллана.
- 2.2.3. Шилдэг багш, суралцагчдыг гадаад, дотоодын сургуулиудад суралцуулах, дадлагажуулах, мэргэшүүлэх ажлыг бодлогоор дэмжинэ.
- 2.2.4. Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрыг шинээр барих ажлыг холбогдох байгууллага, албан тушаалтанд уламжлан, санхүүжилтийг улсын болон орон нутгийн төсөвт суулгуулах ажлыг зохион байгуулна.

2.3. Хөдөлмөр эрхлэлт

- 2.3.1. “Өрх бүр- Ажлын байр” хөтөлбөрийг сумандаа хэрэгжүүлнэ.
- 2.3.2. Орон нутагт хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх бодлогыг хэрэгжүүлж, ажлын байр шинээр бий болгоно.
- 2.3.3. Зорилтот бүлэг болон амьжиргааны баталгаажих төвшингөөс доогуур орлоготой иргэдийг тэргүүн эгнээнд ажлыг байртай болгох зорилт тавин сумын хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг байгууллага, аж ахуйн нэгжтэй хамтран ажиллана.
- 2.3.4. Эмэгтэйчүүдийг ажлын байраар хангах төсөл хөтөлбөр, санал санаачилгыг бодлогоор дэмжиж ажиллана.

ГУРАВ. ЗАСАГЛАЛ

- 3.1. Төрийн байгууллагын үйл ажиллагааг хүртээмжтэй, нээлттэй болгож, төрийн албан хаагчдыг хүнд сурталгүй, авлигаас ангид байх нөхцөлийг бүрдүүлж, “Авлигагүй, нээлттэй, цахим” сум болох зорилт тавин ажиллана.
- 3.2. Сум хөгжүүлэх сангийн зээлийн эх үүсвэрийн зарцуулалт, шалгаруулалтыг иргэдэд ил тод, цахим болгоно.
- 3.3. “Хашаандаа сайхан амьдаръя” хөтөлбөрийг хэрэгжүүлж, өрх бүрийг ногоон байгууламж хийх нөхцөл бололцоог хангах бодлого баримтлан ажиллана.
- 3.4. Хүүхдийг ёс суртахуун, зан заншлын буруу зуршилд автахаас урьдчилан сэргийлэхэд чиглэсэн үйл ажиллагаанд гэр бүл, сургууль, олон нийтийн оролцоог нэмэгдүүлнэ.
- 3.5. Хамтарсан багийн үйл ажиллагааг тогтмолжуулна.
- 3.6. Сумдын хурдан морин уралдааны замыг тогтоон, замын нөхцөлийг сайжруулж, унаач хүүхдийн аюулгүй байдлыг хангах ажлыг хүүхэд хамгаалах байгууллагуудтай хамтран зохион байгуулна.
- 3.7. Гадаад орнуудын болон бүс нутгийн харилцан ашигтай хамтын ажиллагааг хөгжүүлэн, ижил түвшний бүс, мужтай холбоо тогтоож, туршлага судлан, хамтран ажиллах бодлого баримтлан ажиллана.
- 3.8. Хүний эрхийг хамгаалахад төрийн байгууллага, иргэний нийгмийн байгууллага, иргэдийн оролцоог нэмэгдүүлэхэд анхаарч ажиллана.



СЭЛЭНГЭ АЙМГИЙН ОРХОНТУУЛ СУМЫН

АРДЧИЛСАН НАМЫН ХОРОО

